



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн эрсдэлийн аудитын тайлан

ЗҮҮНХАРАА ПОЛИТЕХНИКИЙН КОЛЛЕЖИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН

ҮЙЛ АЖИЛЛАГАА



Ерөнхий дүгнэлт:

Батлагдсан төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэж, цалингийн зардлаас нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд гүйлгэн зарцуулсан байна.

Сүхбаатар сум

2017 он

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	ТАЙЛАНГИЙН АГУУЛГА
Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар	1.Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Үндсэн мэдээлэл
Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа	2.Аудитын дүн БҮЛЭГ 1. Төсвийг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулж байна уу?
Аудитын менежер Б.Батмөнх	1.1. Цалин, НДШ-ийн зардлыг бодитой төлөвлөж, зарцуулсан эсэх? 1.2. Тогтмол зардлыг бодитой төлөвлөж, зарцуулсан уу?
Аудитор Э.Эрдэнэзул	1.3. Хичээл үйлдвэрлэлийн дадлага, хоолны зардлыг бодитой төлөвлөж, зарцуулсан эсэх ? БҮЛЭГ 2. Хөрөнгийн худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж, үнэн зөв тайлагнасан эсэх?
2017 оны 10 сар	2.1. Хөрөнгийн худалдан авалтыг хуулийн дагуу гүйцэтгэсэн үү? 2.2. Хөрөнгийн орлогыг үнэн зөв бүртгэсэн эсэх? БҮЛЭГ 3. Өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлж, хууль журмын дагуу зарцуулж, тайлагнаж байна уу?
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70363036 дугаарын утас, 70363040 дугаарын факсаар харилцана уу.	3.1 Өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлж, санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнасан уу? 3.2 Өөрийн орлогыг холбогдох хууль журмын дагуу зарцуулсан эсэх? Гурав. Илрүүлсэн зөрчил Дөрөв. Аудитын дүгнэлт Тав. Зөвлөмж Холбогдох байгууллагын санал
ХАЯГ:Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум аймгийн ЗДТГ-ын байрны Өргөтгөлд	Саналд өгсөн тайлбар

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд байгууллагын Олон улсын стандарт
БНСУ	Бүгд найрамдах Солонгос улс
БСШУ	Боловсрол, соёл шинжлэх ухаан
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МБСБ	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага
МБСДС	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан
МУ	Монгол Улс
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
НББ	Нягтлан бодох бүртгэл
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХХ	Олон нийттэй харилцах хэлтэс
ОУБ	Олон улсын байгууллага
ХАА	Хөдөө аж ахуй
ХБНГУ	Холбооны бүгд найрамдах Герман улс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
УИХ	Улсын Их Хурал
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт

Зүүнхараа политехникийн коллежийн 2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлийн аудит хийж, дүнг албан тушаалтнуудад танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд эрсдэлийн аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

1. Төсвийг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулж байна уу?
2. Хөрөнгийн худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж, үнэн зөв тайлагнасан эсэх?
3. Өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлж, хууль, журмын дагуу зарцуулж, тайлагнаж байна уу?

Хамарсан хүрээ

Аудитад Зүүнхараа политехникийн коллежийн 2016 оны санхүүгийн зарим үйл ажиллагааг хамруулан шалгалаа.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС-3000-3001/-ийг ашиглан сургуулийн захирал, нягтлан бодогч, эд хариуцагч нартай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, аудитын тайлангийн дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ашиглав.

Ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Аудитад Зүүнхараа политехникийн коллежийн 2016 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл, тайлагнал, нягтлан бодох бүртгэлийн баримтууд болон дараах эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль
- ТБОНӨХБАҮХА тухай хууль
- Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол болон бусад эрхийн актууд, тухайлбал:
- Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”

- Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”, “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”
- Бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг тавьж, аудитор Э.Эрдэнэзул 2017 оны 08 дугаар сарын 23-наас 10 дугаар сарын 10-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Үндсэн мэдээлэл

БСШУ-ны Сайдын 2009 оны 11-р сарын 25-ны өдрийн 522 дугаар тушаалаар Мандал сумын “Зүүнхараа-МСҮТ”-ийг байгуулж, 2014 онд Хөдөлмөрийн яамны сайдын тушаалаар Зүүнхараа политехникийн коллеж болон өргөжсөн байна.

Тус коллеж нь *“Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн чадамжтай, мэргэжилтэй ажилтан бэлтгэх”* гэсэн эрхэм зорилготойгоор хөдөө аж ахуй, үйлдвэрлэл үйлчилгээ, барилга, техникийн салбарын 16 мэргэжлийн чиглэлээр техникийн болон мэргэжлийн боловсрол олгох сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл аван үйл ажиллагаа явуулж байна.

Тус коллеж нь 2016 онд 61 багш ажиллагсад, 412 суралцагсадтайгаар мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулсан байна. Тайлант онд улсын төсвөөс 914,297.6 мянган төгрөгийн, нийгмийн даатгалын сангаас 13,668.3 мянган төгрөгийн, өөрийн орлогоос 3,492.7 мянган төгрөгийн, МБСДС-гаас 4,500.0 мянган төгрөгийн, НҮБ-Хүнс хөдөө аж ахуйн газраас 3,360.0 мянган төгрөгийн, ХБНГУ-ын мэргэжлийн боловсролыг дэмжих GIZ PAO төслөөс 8,444.2 мянган төгрөгийн, Дэлхийн зөн Зүүнхараа салбараас 1,875.0 мянган төгрөгийн, хөрөнгийн орлогын 349,504.9 мянган төгрөгийн, бусад 1,222.5 мянган төгрөгийн зэрэг нийт **1,300,365.2** мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

ХОЁР. АУДИТЫН ДҮН

БҮЛЭГ 1. Батлагдсан орон тоог хэтрүүлснээс жилийн эцэст НДШ, ХХОАТ-д өр үүсгэн, цалингийн зардлаас бусад зардалд гүйлгэн зарцуулсан байна.

1.1 Цалин, НДШ-ийн зардлыг бодитой төлөвлөж, зарцуулсан эсэх?

Зүүнхараа политехникийн коллежийн 2016 оны батлагдсан төсвийн 64.4 хувийг ажиллагсадтай холбогдсон зардал, 15.0 хувийг тогтмол зардал, 7.2 хувийг нормативт зардал, 13.4 хувийг бусад бараа үйлчилгээний зардал эзэлж байна.

Зүүнхараа политехникийн коллеж нь 2016 онд удирдах-1, гүйцэтгэх- 45, үйлчлэх 24 зэрэг нийт 70 орон тоотой, 606,943.0 мянган төгрөгийн цалингийн сантай ажиллахаар төсвийн төсөл боловсруулсан боловч удирдах 3, гүйцэтгэх 39, үйлчлэх 19, нийт 61 орон тоотойгоор сургалтын үйл ажиллагаа явуулахаар цалин хөлс, нэмэгдэл урамшуулалд 536,192.2 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Хүснэгт №1

Зардлын ангилал	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт, хэтрэлт
Цалин, хөлс нэмэгдэл урамшуулал	536,192.2	535,442.1	-750.1
Нийгмийн даатгалын шимтгэл	59,683.9	59,097.4	-586,5
Ажиллагсадтай холбогдсон нийт зардал	595,876.1	594,539.5	-1,336,6

Хөдөлмөрийн сайдын “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дүрэм, бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай” 2016 оны А/30 дугаар тушаалаар Зүүнхараа политехникийн коллежийн бүтэц орон тоог 61 байхаар баталсан байхад 1-4 сард батлагдсан орон тоог 3-р хэтрүүлж /харуул-2, өлгүүрийн жижүүр/ ажиллуулснаас тайлант онд цалин хөлс, нэмэгдэл урамшуулалд 536,192.2 мянган төгрөг тооцогдож, гүйцэтгэлээр 535,442.1 мянган төгрөгийг зарцуулан, жилийн эцэст ХХОАТ-д 750.1 мянган төгрөгийн өр төлбөртэй, НДШ-ийн зардалд 59,683.9 мянган төгрөг тооцогдож, гүйцэтгэлээр 59,097.4 мянган төгрөгийг зарцуулан жилийн эцэст 586.5 мянган төгрөгийн өр төлбөртэй тайлагнагдсан байна.

Аудитын явцад цалингийн зардлын зарцуулалтыг цалингийн баримт, цагийн бүртгэл, холбогдох тушаал шийдвэртэй нь тулган баталгаажуулахад цалингийн зардлаас холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр 3 хүнд ажлаас халагдсаны нэг удаагийн тэтгэмжийн 1,185.8 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16

дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Цалингийн урьдчилгааг тооцооны дансаар дамжуулан бүртгээгүйгээс ерөнхий нягтлан бодогч Н.Үүрцайхаас дутуу суутгасан цалингийн урьдчилгаа 600.0 мянган төгрөгийг жилийн эцэст санхүүгийн тайланд авлага үүсгээгүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4¹.2² дахь заалтыг зөрчсөн байна.

Тус коллежийн дотоод журмын 9.2.а-д багш ажиллагсдад нэг сард хоолны нэмэгдлийг 55.0 мянган төгрөгөөр тооцож олгохоор баталсны дагуу тайлант онд нийт **31,101.3** мянган төгрөгийн унаа хоолны нэмэгдэл олгосон ч Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1³, 22 дугаар зүйлийн 22.1.4⁴-д заасныг зөрчин **311.0** мянган төгрөгийн ХХОАТ-ыг дутуу суутгасан байна.

Тайлант оны 1-р сард нягтлан бодогч Б.Энхцэцэг, нярав Ж.Бямбасүрэн нарт ур чадварын нэмэгдлийг тушаалд зааснаас 5.0 хувиар илүү тооцоноос **49.2** мянган төгрөгийг илүү олгосон байна.

Тус коллежийн цалингийн зардлын гүйцэтгэлийг бүтцээр нь авч үзвэл 74.4 хувийг үндсэн цалин, 25.6 хувийг нэмэгдэл хөлс, урамшуулал эзэлж байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 2

№	Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал	Дүн	Эзлэх хувь
1	Үндсэн цалин	398,426.7	74.4%
2	Ур чадвар	26,278.2	4.9%
3	Цагийн багш	3,078.5	0.6%
4	Зэргийн нэмэгдэл	8,874.4	1.7%
5	Илүү цаг	7,101.8	1.3%
6	Кредитийн нэмэгдэл	18,423.7	3.4%
7	Нэмэгдэл хөлс	11,353.8	2.1%
8	Үр дүнгийн гэрээ	28,300.4	5.3%
9	Бусад	2,503.1	0.5%
10	Хоол	31,101.3	5.8%
	НИЙТ	535,442.1	

¹ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ.

² Бүх хөрөнгө оруулалт, хөрөнгө, авлага

³ Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал дээр ажил олгогчоос нэмж олгож байгаа тухайн ажилтнаас албан үүргээ гүйцэтгэхэд шууд холбогдолгүй дараахь бараа, үйлчилгээний орлогыг албан татвар ногдох шууд бус орлогод хамруулна

⁴ Шууд бус орлогод ногдуулах албан татварыг тухайн орлогын дүнгээр

Дотуур байрны барилгын худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, худалдан авсан, сургуулийн засварын үйл ажиллагааг ажлын бус өдрүүдэд илүү цагаар ажиллаж гүйцэтгэсэн, тэмцээн уралдаанд амжилттай оролцсон, баяр наадмын өдрүүдэд ажилласан зэрэг шалтгаанаар үндсэн цалингийн 25-100 хувиар нэмэгдэл хөлс тооцон, нийт **11,353.8** мянган төгрөгийг хавтгайруулан олгосон нь төсвийг хэт үрэлгэн байдлаар зарцуулсан байна гэж үзэхэд хүргэж байна. /Хавсралт №1-ээр харуулав/

1.2 Тогтмол зардлыг бодитой төлөвлөж, зарцуулсан үү ?

Зүүнхараа политехникийн коллежийн 2016 оны тогтмол зардалд 139,178.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 126,656.8 мянган төгрөгийг зарцуулсан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №3

№	Зардал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт хэтрэлт
1	Гэрэл цахилгаан	17,435.0	11,801.4	-5,633.6
2	Түлш халаалт	103,564.0	101,476.5	-2,087.5
3	Цэвэр, бохир ус	18,179.0	13,378.9	-4,800.1
	НИЙТ	139,178.0	126,656.8	-12,521.2

Тус коллеж нь “Сэлэнгэ Зүүнхараа” ОНӨААТҮГ-тай байгуулсан дулаан, цэвэр усаар хангах гэрээний дагуу 2016 онд хичээлийн болон дотуур байрны халаалтад 10141 м3 дулаан хэрэглэж, 1 м3 дулааныг 1294.7 төгрөгөөр, 1 м3 цэвэр усыг 3575 төгрөгөөр тус тус худалдан авахаар гэрээ байгуулсан байна.

Түлш халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир усны төлбөрийг сар бүр ханган нийлүүлэгчийн нэхэмжлэхийн дагуу хийж гүйцэтгэн, жилийн эцэст тооцоо нийлсэн актаар баталгаажуулан ажиллаж, төсвийн үндэслэлгүй төлөвлөлтөөс үүсэлтэй 12,521.2 мянган төгрөгийн хэмнэлтийг жилийн эцэст татан төвлөрүүлсэн байна.

1.3 Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлага, хоолны зардлыг бодитой төлөвлөж, зарцуулсан эсэх?

Политехникийн коллежийн хоол, хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардлын 2016 оны батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №4

Зардлын ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт /-/
Хоол	38,102.0	29,475.4	-8,626.6
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлага	50,983.8	50,979.3	-4.5
НИЙТ	89,085.8	80,454.7	-8,631.1

Тус коллежийн дотуур байрны хүүхдийн хоолны зардалд 38,102.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 29,475.4 мянган төгрөгийг зарцуулж, суралцагсдын тоог хэт өндрөөр төлөвлөснөөс үндэслэлтэй 8,626.6 төгрөгийн хэмнэлтийг жилийн эцэст татан төвлөрүүлсэн байна.

**Зүүнхараа политехникийн коллежийн дотуур байрны
хүүхдийн хоолны нормативт зардлын тооцоо**

Хүснэгт №5

Сар	Хүүхдийн тоо	Нэг хүүхдэд ногдох нормативт зардал	Нормативт төсөв	Бодит төсвийн гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт /-/
1 сар	1166	2315	2,699.3	2,742.1	42.8
2 сар	987	2315	2,284.9	2,327.2	42.3
3 сар	1757	2315	4,067.5	4,045.8	-21.7
4 сар	1879	2315	4,349.9	4,363.9	13.9
5 сар	1821	2315	4,215.6	4,225.9	10.3
9 сар	315	2315	729.2	725.9	-3.2
10 сар	950	2315	2,199.3	2,200.9	1.6
11 сар	1330	2315	3,078.9	3,082.9	3.9
12 сар	1462	2315	3,384.5	3,384.5	-
ДҮН	11667		27,009.1	27,099.2	90.1

Хүснэгтээс харахад тайлант онд 11667 хүүхдийн хоолны зардалд 27,099.2 мянган төгрөгийг зарцуулж, Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 106 тоот тогтоолоор баталсан нормативт зардлыг 90.1 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Тус коллежийн хичээл, сургалт үйлдвэрлэлийн дадлагын зардалд 50,983.8 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 50,979.3 мянган төгрөгийн зарцуулсан байна.

Тайлант онд хичээл, сургалт үйлдвэрлэлийн дадлагын зардлаас худалдан авсан **33,569.2** мянган төгрөгийн хангамжийн материалыг тухай бүрд нь бус бөөн дүнгээр бүртгэсэн байгаа нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх

үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

БҮЛЭГ 2. Дотуур байрны хүүхдийн хоолны махны худалдан авалтын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулаагүй байна.

2.1 Хөрөнгийн худалдан авалтыг хуулийн дагуу гүйцэтгэсэн эсэх ?

Тус коллеж нь 2016 онд төсвийн хөрөнгөөр 3,044.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,800.0 мянган төгрөгийн үсчний ангийн сандал тэргэнцэр, 3,345.1 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 7,279.1 мянган төгрөгийн аж ахуйн материал, 8,061.6 мянган төгрөгийн түлш, шатах тослох материал, 1,901.1 мянган төгрөгийн засварын материал, 27,270.5 мянган төгрөгийн хүнсний материал, 42,498.2 мянган төгрөгийн хангамжийн материал, 415.1 мянган төгрөгийн эм боох материал зэрэг нийт 95,614.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авчээ.

Тус коллеж нь “Шүүтийн өвөр” ХХК, “Томон” ХХК-уудтай байгуулсан хүнсний бүтээгдэхүүн худалдах, худалдан авах тухай гэрээний дагуу 14,260.5 мянган төгрөгийн мах худалдан авахдаа бэлтгэн нийлүүлэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулаагүй байгаа нь Засгийн газрын 2013 оны 68 дугаар “Босго үнэ шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтаар баталсан “*Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 10,0 сая төгрөг*”, “*Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа 50,0 сая, ажил 80,0 сая төгрөг*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгагдсан Зүүнхараа политехникийн коллежийн дотуур байр худалдан авах төсөл, арга хэмжээний хэрэгжүүлэх эрхийг Хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 3/447 дугаар албан бичгээр политехникийн коллежийн захиралд шилжүүлсэн байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.1⁵ дэх заалтын дагуу Зүүнхараа политехникийн коллежийн захирлын 2016 оны А/11 дугаар тушаалаар НТШ-ын үнэлгээний хороо байгуулан, тендерийн урилгыг Өдрийн сонин, Засгийн газрын цахим худалдан авах ажиллагааны сайтад тавьж, худалдан авах ажиллагааг зохион байгуулан, мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийгдээгүй байхад иргэн А.Мөнхзулын эзэмшлийн 242м² талбай бүхий 2 давхар барилгыг 285,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан байна.

Гэвч Зүүнхараа политехникийн коллежийн захирлын 2015 оны 09-р сарын 22-ны өдрийн 39 дугаар албан бичгээр буюу худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас жилийн өмнө Хөдөлмөрийн яамны сайд Г.Баярсайханд хандан дээрх барилгыг худалдан авахад шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэж өгөх тухай

⁵ Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг энэ хуулийн 8.1.1-д заасан дээд хязгаараас давсан тохиолдолд захиалагч үнэлгээний хороо байгуулна.

албан бичгийг хүргүүлсэн байна. Өөрөөр хэлбэл худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас нэг жилийн өмнө худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг шууд аргаар сонгон шалгаруулсан байсан бөгөөд 2016 онд зохион байгуулсан сонгон шалгаруулалт нь ор нэр төдий болж, санхүүжилтийг Хөдөлмөрийн яамнаас иргэн А.Мөнхзулд шууд шилжүүлсэн байна.

Аудитын явцад дээрх барилгын ашиглалттай танилцахад 1-р давхарыг оёдлын ангийн дадлагын газар болгон тохижуулж, 2 давхарыг 24 хүүхдийн багтаамжтай охидын дотуур байрны зориулалтаар тохижуулсан байна.

/1-р давхар оёдлын ангийн дадлагын газар/



/2-р давхар дотуур байр/



2.Хөрөнгийн орлогыг үнэн зөв бүртгэсэн эсэх ?

2016 онд худалдан авсан 95,614.9 мянган төгрөгийн болон үнэ төлбөргүй шилжин ирсэн 349,504.9 мянган үндсэн хөрөнгө, бараа материалыг бүртгэлд бүрэн тусгаж, тайлагнасан байна. Хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 6

№	Дансны нэр	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн		Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
			Худалдаж авсан	Хандив, тусламж, бусад		
1	Барилга	606587,6		285000,0	-	891587,6
2	Авто тээврийн хэрэгсэл	350016,4	-	-	-	350016,4
3	Тоног төхөөрөмж	357294,8	3044,3	55269,5	-	415608,6
4	Тавилга эд хогшил	112549,3	1800,0	1274,7	-	115624,0
5	Нийтийн эзэмшлийн байгууламж	64127,8	-	-	-	64127,8
6	Ном	16322,7	-	-	-	16322,7
7	Биет бус хөрөнгө	16348,0	-	4500,0	-	20848,0

8	Бусад үндсэн хөрөнгө	28217,9	-	-	-	28217,9
	ҮХ-ийн дүн	1551464,5	4844,3	346044,2	-	1898967,9
1	Бичиг хэргийн материал	156,4	3345,1	-	3352,4	149,0
2	Аж ахуйн материал	19355,4	7279,1	7960,7	5291,7	29303,5
3	Түлш шатах тослох материал	2042,4	8061,6	-	6503,9	3600,0
4	Хүнсний материал	6879,1	27270,5	-	27089,4	7060,3
5	Эм боох материал	-	415,1	-	415,1	-
6	Сэлбэг хэрэгсэл	60023,3	-	-	-	60023,3
7	Засварын материал	9301,6	1901,1	-	1901,1	9301,6
8	Мал	9545,0	-	-	-	9545,0
9	Бусад материал	67249,5	42498,2	-	33569,2	76178,5
	БМ-ийн дүн	174552,7	90770,6	7960,7	78122,9	195161,1

Тус коллежийн 2013 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн эрсдэлийн аудитаар илэрсэн “Дэлхийн зөн” ОУБ-ын хандиваар байгуулагдсан ХАА-н фермерийн ангийн дадлагын газар “Агропарк-1”, БНСУ-ын Ы сон аймгийн ХАА-н газрын тусламжаар байгуулагдсан “Агропарк-2”-ыг үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусгаагүй байсан зөрчлийг арилгаж, үндсэн хөрөнгийн бүртгэл, тайланд тусгасан байна.

Аудитаар хөрөнгийн орлого, зарлагатай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ❖ Тайлант онд малын 1,225.0 мянган төгрөгийн нас дэвшлийн орлогыг бүртгэлд тусгаагүй байна.
- ❖ Бараа материалын дансанд **3,869.9** мянган төгрөгийн тавилга, эд хогшил, бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан *"Төсөвт байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"*, УСНББОУС-17 *"Үндсэн хөрөнгө" стандартын 13 (а), (б)* заалтуудыг тус тус зөрчсөн байна.
- ❖ ХБНГУ-ын мэргэжлийн боловсролыг дэмжих GIZ PAO төслийн санхүүжилтээр худалдан авсан **2,000.0** мянган төгрөгийн үнэ бүхий зургийн аппарат, уран хөрөөг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлгүй шууд зардлаар тайлагнасан байна.

Зүүнхараа политехникийн коллежийн захирлын 2016 оны А/33, А/71 дугаар тушаалуудаар хагас жилийн болон жилийн эцсийн хөрөнгийн тооллогын комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилон, гүйцэтгүүлж, хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийг данс бүртгэлд тусгаж, үлдэгдлийг баталгаажуулсан байна.

БҮЛЭГ 3. Тайлант онд өөрийн орлогын төлөвлөгөөг 37.8 хувиар тасалдуулсан байна.

3.1 Өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлж, санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнасан үү?

Тус байгууллагын 2016 оны өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №7

№	Өөрийн орлого	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Үндсэн үйл ажиллагааны орлого	3,124.0	733.7	-2,390.3
2	Туслах үйл ажиллагааны орлого	2,500.0	2,759.0	259,0
	НИЙТ	5,624.0	3,492.7	-2,131.3

Хүснэгтээс харахад тус байгууллага нь 2016 онд үндсэн үйл ажиллагааны орлогоос 3,124.0 мянган төгрөгийн /түр сургалтаас 1,000.0 мянган төгрөгийн, үйлдвэр сургалт дадлагаар ажил хийж гүйцэтгэсний 1,500.0 мянган төгрөгийн, бүртгэлийн хураамж давтан шалгалтаас 624.0 мянган төгрөгийн/, туслах үйл ажиллагааны орлогоос 2,500.0 мянган төгрөгийн /төмс хүнсний ногоо тариалж, оюутны хоолны материал бэлтгэх/ зэрэг нийт 5,624.0 мянган төгрөгийн өөрийн орлогыг төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

Гэвч тайлант онд 3,492.7 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 37,8 хувиар тасалдуулсан байна. Тайлант онд үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг дараах эх үүсвэрээс төвлөрүүлсэн байна. Тодруулбал:

- Политехникийн коллежид элсэгчдийн элсэлтийн хураамжаас 967.7 мянган төгрөгийг,
- Заалны түрээсээс 75.0 мянган төгрөгийг,
- Хүлэмжийн түрээсийн орлогоос 2,450.0 мянган төгрөгийг тус тус бүрдүүлж, жилийн эцсийн санхүүгийн тайланд тайлагнасан байна.

Тус коллеж нь оёдол, нийтийн хоолны ангийн оюутнуудын дадлагын ажлаас бий болсон бүтээгдэхүүнийг борлуулах, барилга, сантехник, авто засварын ангийн оюутнуудын дадлагын ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэн ажлын хөлсний тодорхой хувийг өөрийн орлогод төвлөрүүлэх замаар үндсэн үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлэх бүрэн боломжтой байна. Гэтэл тус политехникийн коллеж нь тайлант онд хичээл, сургалт үйлвэрлэлийн дадлагын зардалд 50,979.3 мянган төгрөгийг зарцуулсан ч ямар ч орлого төвлөрүүлээгүй байна.

Иймээс дээрх байдалд дүгнэлт хийж, дотоод нөөц боломжийг бүрэн ашиглан өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах нь зүйтэй юм.

3.2 Өөрийн орлогыг холбогдох хууль журмын дагуу зарцуулсан эсэх?

Тус политехникийн коллеж нь 2016 онд өөрийн үйл ажиллагаанаас төвлөрсөн 3,492.7 мянган төгрөгийн орлогыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан байна.

ГУРАВ. АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Албан шаардлага:

- ❖ Холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр цалингийн зардлаас нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд **1,185.8** мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан,
- ❖ Цалингийн урьдчилгааг тооцооны дансаар дамжуулан бүртгээгүйгээс ерөнхий нягтлан бодогч Н.Үүрцайхын дутуу суутгасан цалингийн урьдчилгаа **600.0** мянган төгрөгийг жилийн эцэст санхүүгийн тайланд авлага үүсгээгүй,
- ❖ Дотуур байрны засварын ажлыг ажлын бус өдрүүдэд хийж гүйцэтгэсэн, тэмцээн уралдаанд амжилттай оролцсон, баяр наадмын өдрүүдэд ажилласан зэрэг шалтгаанаар үндсэн цалингийн 25-100 хувиар нэмэгдэл хөлс тооцон, нийт **11,353.8** мянган төгрөгийг олгосон,
- ❖ Махны худалдан авалтын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулаагүй **-14,260.5** мянган төгрөг
- ❖ Хичээл, сургалт үйлдвэрлэлийн дадлагын зардлаас худалдан авсан хангамжийн материалыг тухай бүр нь бус бөөн дүнгээр журналд бүртгэсэн- **33,569.2** мянган төгрөг
- ❖ Бараа материалын дансанд тавилга, эд хогшил, бүртгэсэн-**3,869.9** мянган төгрөг,
- ❖ ХБНГУ-ын мэргэжлийн боловсролыг дэмжих GIZ PAO төслийн санхүүжилтээр худалдан авсан **2,000.0** мянган төгрөгийн үнэ бүхий зургийн аппарат, уран хөрөөг хөрөнгийн дансанд бүртгэлгүй шууд зардлаар бүртгэсэн,
- ❖ Малын нас дэвшилтийн **1,225.0** мянган төгрөгийн орлогыг бүртгэлд тусгаагүй зэрэг нийт **68,064.2** мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөрчил арилгах албан шаардлага бичигдлээ.

ДӨРӨВ. АУДИТЫН ДҮГНЭЛТ

- ❖ Холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр цалингийн зардлаас нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд гүйлгэн зарцуулсан байна,
- ❖ Төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэсэн байна.
- ❖ Цалингийн урьдчилгааг дутуу суутгаж, санхүүгийн тайланд авлага үүсгээгүй байна.

- ❖ Цалингийн санг үндэслэлгүй төлөвлөснөөс үүдэлтэй хэмнэлтээс багш ажиллагсдад хавтгайруулан нэмэгдэл хөлс олгосон байна.
- ❖ Махны худалдан авалтыг хуулийн дагуу гүйцэтгээгүй байна.
- ❖ Бараа материалын дансанд тавилга, эд хогшил үндсэн хөрөнгө бүртгэсэн байна.
- ❖ Төслийн санхүүжилтээр худалдан авсан хөрөнгийг шууд зардлаар тайлагнасан байна.
- ❖ Малын дансны хөдлөл өөрчлөлтийг бүртгээгүй байна.
- ❖ Мэргэжлийн байгууллагын үнэлгээ хийгдээгүй дотуур байрны барилгын худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг хууль, журмын дагуу сонгон шалгаруулалгүйгээр, 285,0 сая төгрөгөөр худалдан авсан байна.

ТАВ. АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Захирал Ц.Эрдэнэчулуун-д:

- ❖ Төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах, цалингийн хэмнэлтээс хавтгайруулан нэмэгдэл хөлс олгож буй зөрчлийг таслан зогсоох.
- ❖ Худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу зохион байгуулж байх.
- ❖ Өөрийн орлогыг бодитоор төлөвлөж, дотоод нөөц бололцоогоо ашиглах замаар нэмэгдүүлэх .

Ерөнхий нягтлан бодогч Н.Үүрцайх-д:

- ❖ Батлагдсан төсвийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.
- ❖ ХХОАТ-ын тухай хуулийн дагуу багш ажилчдад олгож байгаа унаа, хоолны нэмэгдлээс ХХОАТ-ын суутгалыг суутгах.
- ❖ Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-г мөрдөн ажиллаж, цалин болон хангамжийн материалыг тооцооны дансаар дамжуулан бүртгэж байх.

Зүүнхараа политехникийн коллежийн багш, ажиллагсдад олгосон нэмэгдэл хөлсний түүвэр

№	Нэмэгдэл хөлс олгосон тушаал шийдвэр утга	Ажилтны нэр	Албан тушаал	Хувь	Авсан цалин
1	2016.06.20 Б/52 дугаар тушаалаар Төсвийн хэмнэлт хийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлэн, дотуур байрны худалдан авах ажиллагааг НТШ-р үр дүнтэй зохион байгуулж, худалдан авсан, Азийн хөгжлийн банкны төсөл хөтөлбөрт хамрагдах ажилд холбогдох материалыг гарган сургуулийн засварын үйл ажиллагааг туслан гүйцэтгэгчгүйгээр ажлын бус өдрүүдэд илүү цагаар ажилласан ажилчдад үндсэн цалингийн 25-50 хувиар нэмэгдэл хөлс олгосон байна.	Х.Одонтуяа	ЗАА-н менежер	100%	641,091
		Н.Үүрцайх	Ахлах нягтлан бодогч	100%	633,221
		Г.Сэлэнгэ	Хүний нөөц, гадаад харилцаа хариуцсан	100%	608,457
		Б.Энхцэцэг	Тооцооны нягтлан бодогч	100%	556,393
		Ж.Бямбасүрэн	Нярав	100%	427,360
		П.Нарантуяа	Дотуур байрны багш	80%	440,295
		Б.Туул	Дотуур байрны багш	80%	317,483
		Ц.Идэрсайхан	Дотуур байрны багш	80%	431,637
		О.Оюунцацрал	Дотуур байрны багш	80%	428,228
		Д.Шүрэнцэцэг	ХШЧБ ажилтан	25%	139,098
		Б.Эрдэнэтуяа	Бичиг хэрэг, архивын ажилтан	25%	111,714
		Ц.Нэргүй	Тогооч	25%	101,247
		О.Баясгалан	Тогооч	25%	107,797
		Н.Баярцэцэг	Номын санч	25%	104,895
		Х.Пүрэвдорж	Жолооч	25%	103,099
		В.Пүрэв-Очир	Өлгүүрийн жижүүр	25%	93,397
		Т.Эрдэнэцогт	Цахилгаанчин	25%	113,038
		Т.Батцацрал	Эмч	25%	112,556
		С.Саранчимэг	Үйлчлэгч	25%	95,010
		Ж.Мөнхцэцэг	Үйлчлэгч	25%	95,010
2	2016.06.20 Б/53 дугаар тушаалаар Төсвийн хэмнэлт хийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлэн, дотуур байрны худалдан авах ажиллагааг НТШ-р үр дүнтэй зохион байгуулж, худалдан авсан, Азийн хөгжлийн банкны төсөл хөтөлбөрт хамрагдах ажилд холбогдох материалыг гарган сургуулийн засварын үйл ажиллагааг туслан гүйцэтгэгчгүйгээр ажлын бус өдрүүдэд илүү цагаар	О.Дамдинсүрэн	СА-ны менежер	50%	362,517
		Л.Нармандах	Менежер	50%	337,122
		Л.Энхзул	Менежер	50%	337,122
		Б.Наранбаатар	Нийгмийн ажилтан	25%	133,822
		Х.Булгантамир	Статистик мэдээ, ХЗЗ-ийн судалгаа, сурталчилгаа хариуцсан ажилтан	25%	133,822

	ажилласан ажилчдад үндсэн цалингийн 25-50 хувиар нэмэгдэл хөлс олгосон байна.				
3	2016.11.23 Б/80 дугаар тушаалаар Төвийн бүсийн МБСБ-уудын багш нарын урлагийн 2-р наадамд 5 төрлөөр оролцож 1-р байр шилжин явах цом авсан багш, ажилчдад үндсэн цалингийн 40 хувиар нэмэгдэл хөлс олгосон.	О.Дамдинсүрэн	СА-ны менежер	40%	290,013
		Н.Үүрцайх	Ахлах нягтлан бодогч	40%	253,289
		Г.Сэлэнгэ	Хүний нөөц, гадаад харилцаа хариуцсан	40%	243,382
		Л.Энхзул	Арга зүйч	40%	269,697
		Б.Наранбаатар	Нийгмийн ажилтан	40%	214,114
		Л.Нармандах	Арга зүйч	40%	269,697
		С.Одбаяр	Биеийн тамирын багш	40%	224,346
		Г.Батхуяг	Сантехникийн багш	40%	224,346
		Ц.Батцэнгэл	Барилгын мэргэжлийн багш	40%	228,892
		Н.Мөнгөнзул	Математикийн багш	40%	224,346
		Х.Бямбасүрэн	Монгол хэл уран зохиолын багш	40%	228,892
		Х.Булгантамир	СМХЗЗСХ ажилтан	40%	214,114
		О.Дэлгэрцэцэг	Үсчиний мэргэжлийн багш	40%	222,557
4	Баяр наадмын өдрүүдэд ажилласан 1 өдрийн хөлс олгосон. /8-р сард/ 15 хүнд				1,073,500
					207,258
	НИЙТ				11,353,874